



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/94

Номгон

Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээний т  
удирдамж, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, "Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.6, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6, Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.3.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээний удирдамжийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээний удирдамж, төлөвлөгөөг хэрэгжүүлж, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Насан туршийн боловсролын төв (Д.Амгалан), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Э.Энхтөр), Эрүүл мэндийн газар (Н. Энхжаргал), Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар (Н.Мэндбаяр), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг), Онцгой байдлын газар (Ж.Алтангэрэл), Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК (Ж. Уламбаяр), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг байгууллагын болон төсөл хөтөлбөр, иргэд, аж ахуйн нэгжийн хандив тусламжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг байгууллагын дарга, сумдын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

643310225

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар  
сарын 12 ны өдрийн 199 дүгээр  
захирамжийн нэгдүгээр хавсралт

## ӨРХИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Монгол улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.3 зорилт, Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.6, Аймгийн засаг дарга, Сумын засаг дарга нарын хооронд байгуулсан хамтран ажиллах гэрээг тус тус үндэслэн Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Энэхүү арга хэмжээ нь зорилтот өрхийн гишүүдийг зөвхөн ажил эрхлэх, санхүүгийн нэмэлт орлогоор бус нийгмийн харилцаа, суралцах хэрэгцээ шаардлага, аюулгүй орчинд ажиллаж амьдрах, амьдралын нөхцөл боломжоо дээшлүүлэх боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамруулах, гэр бүлийн боловсрол олгох, хөдөлмөрийн насны, ажил эрхлэх чадвартай гишүүдийг ажил хөдөлмөртэй болгох зэргээр нийгмийн үйлчилгээг өрхөд хүргэх, салбар хоорондын уялдаа холбоотойгоор зохион байгуулж, зорилтот өрхөд бодит үр дүн, ахицыг гаргах нь нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлэх нэн чухал ажил болно.

**Зорилго:** “Нийгмийн идэвх санаачилга сайтай, ажил эрхлэх, сурч боловсрох хүсэл эрмэлзэл бүхий өрхийг тодорхойлж тэдгээр өрх, өрхийн гишүүдийн эрэлт хэрэгцээ, санаачилга, боломжид тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт зэрэг үйлчилгээг цогцоор нь хүргэх замаар зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулан өрхийн хөгжлийн тогтвортой байдлыг бий болгоход оршино.

### Зорилт:

Сонгогдсон өрхүүдийн нөхцөл байдлын үнэлгээг гаргах, үнэлгээнд суурилсан төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

Сургалт нөлөөллийн үйл ажиллагааг системтэй хүргэж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулна.

Өрхийн гадаад болон дотоод эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## 2.

Өрхийн гишүүдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх сэтгэлгээ хандлагыг төлөвшүүлэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх боломжоор хангана.

**Хамрах хүрээ:** Жил бүр зорилтот 240 өрх

**Хугацаа:** 2023 оны 02 дугаар сарын 13- ны өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 15 хүртэл

**Ерөнхий зохион байгуулагч:** Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Насан туршийн боловсролын төв

**Хамтран зохион байгуулагч:** Сумдын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Онцгой байдлын газар, Политехникийн коллеж, Жаргалтай амьдрал төв, “Хот тохижилт” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар “Цэвэр хот” Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар орон нутагт хэрэгжүүлэх баг.

**Үйл ажиллагааны чиглэл:**

Нөхцөл байдлын суурь, явцын, эцсийн үнэлгээг хийх

Нөхцөл байдлын үнэлгээнд суурилсан өрх бүртэй ажиллах төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх

Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн үйлчилгээнд бүрэн хамруулах

Өрхийн эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх ажлыг зохион байгуулах

Өрхийн гишүүдийг хөдөлмөрлөх, орлого нэмэгдүүлэх боломжийг судалж, мэргэжил олгох сургалтад хамруулах, ажилд зуучлах, дэмжлэг үзүүлэх

Аймаг, орон нутагт ажиллаж байгаа төсөл, хөтөлбөрт холбон зуучлах

Иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах

Тайлант арга хэмжээг зохион байгуулах

**Орон нутагт хэрэгжүүлэх баг**

Сумдын Тамгын газрын дарга, Нийгмийн бодлогын ажилтан, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн, ЕБС-ийн захирал, нийгмийн ажилтан, Насан туршийн боловсролын нэгжийн менежер, багш, цэцэрлэгийн эрхлэгч, Эрүүл мэндийн төвийн дарга, нийгмийн ажилтан, өрхийн болон багийн эмч, байгаль хамгаалагч, багийн Засаг дарга, эрчим хүчний байцаагч, хэсгийн төлөөлөгч, цагдаа.

**Хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх:**

1.Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээний явцын тайланг жил бүрийн 06 дугаар сарын 05-ны дотор файлаар авна.

3.

2.Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээний нэгдсэн тайланг жил бүрийн 11 сарын 10-ны дотор файл болон цаасан хэлбэрээр авна.

3.Аймгийн хэмжээний нэгдсэн тайланг гаргаж, үр дүнг сум бүрээр үнэлж дүгнэнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын *2023* оны *02* дугаар сарын *13* ны өдрийн *А.1.97* дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралт

**ӨРХИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ  
(2023-2024 ОН)**

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хамрах хүрээ	Хүрэх үр дүн	Хариуцан ажиллах байгууллага	Хамтран ажиллах байгууллага
1	2	3	4	5	6	7
1	Өрхийг үзүүлэлтийн сонгох шалгуур дагуу	Жил бүрийн 02 сарын 08-10	Сонгогдсон өрхүүд	Шалгуурын дагуу нийт 240 өрх сонгогдсон байна.	Насан туршийн боловсролын төв (НТБТ)	Сумын Тамгын газар
2	Сонгогдсон өрхүүдэд нөхцөл үнэлгээ хийх байдлын	Жил бүрийн 02 сарын 10-14	Сонгогдсон өрхүүд	Үнэлгээг хийж өрхүүдийн нөхцөл байдлыг тодорхойлсон байна.	Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар (ХХҮГ), НТБТ, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ)	Хэрэгжилтийн баг
3	Нөхцөл байдлын үнэлгээнд суурилсан өрх бүрийн төлөвлөгөө боловсруулах	Жил бүрийн 02 сарын 15-17	Сонгогдсон өрх бүрээр	Өрх бүрт тохирсон төлөвлөгөөг гаргасан байна.	НТБТ, ХХҮГ, ГБХЗХГ	Хэрэгжилтийн баг
4	Өрх төлөвлөгөөнд суурилсан нэгжийн бүрийн	Жил бүрийн 02 сарын 17	Сонгогдсон өрх бүрээр	Нэгжийн менежер, багш нар өрх бүрийн төлөвлөгөөг нэгтгэн төлөвлөгөө гаргасан.	Насан туршийн боловсролын нэгж (НТБН), НТБТ	Орон нутагт хэрэгжүүлэх баг

1	2	3	4	5	6	7
	нэгдсэн төлөвлөгөө			байна		
5	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах	Жил бүрийн 3 сард	0-5 насны хүүхдүүд	СӨБ-д бүрэн хамрагдсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны газар (БШУГ), Цэцэрлэгүүд	Сумын ЗДТГ, багийн дарга
6	Сургуулийн гадна байгаа хүүхэд, залуучуудыг Ерөнхий боловсролын сургууль, Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт хамруулах	Жил бүрийн 9-сард	Хүүхэд, залуучууд	Ерөнхий боловсрол олгох сургалтад хамрагдсан байна.	БШУГ, НТБТ	Сумын ЗДТГ, ЕБС, НТБН
7	Амьдрах ухаанд суурилсан бичиг үсгийн чадвар олгох сургалт зохион байгуулах	Тогтмол	Өрхийн бичиг үсгийн чадваргүй гишүүд	Бичиг үсгийн чадвар дээшилнэ.	НТБТ	Сумын ЗДТГ, НТБН
8	Амьдрах ухааны боловсрол олгох сургалт	Жил бүрийн 9 сард	Сонгогдсон өрхийн бүх гишүүдэд	Өрхийн боловсролын гишүүдийн түвшин дээшилнэ.	НТБТ, ГБХЗХГ,	ЕБС, НТБН,
9	Гэр бүлийн боловсрол олгох сургалт					
10	Санхүүгийн боловсрол олгох сургалт					
11	Иргэний боловсрол олгох сургалт	Жил бүрийн 9 сард	Сонгогдсон өрхийн бүх гишүүдэд	Өрхийн боловсролын гишүүдийн түвшин мэдлэг, мэдээлэл, чадвар, хандлагад эерэг өөрчлөлт гарна.	НТБТ, Байгал орчин, аялал жуучлалын газар (БОАЖГ), Эрүүл мэндийн газар ЭМГ, Нийгмийн даатгал, ХХҮГ, ГБХЗХГ.	ЕБС, НТБН, багийн дарга засаг
12	Тогтвортой хөгжлийн боловсрол олгох сургалт					
13	Эрүүл мэндийн боловсрол олгох					

1	2	3	4	5	6	7
14	Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай эмчилгээ үйлчилгээ үзүүлэх	Жил бүрийн 2-3 улиралд	Сонгогдсон өрхийн бүх гишүүдэд	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулснаар эрүүл мэндийн асуудлаа шийдвэрлэнэ.	Эрүүл мэндийн газар	Өрхийн эмнэлэг, сумын Эрүүл мэндийн төв, багийн эмч
15	0-5 настай хүүхдийн өсөлт хөгжилтийг хянах, дэмжих		0-5 насны хүүхэд			
16	Эмэгтэйчүүдийн хөх, умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх шинжилгээнд хамруулах.		Сонгогдсон өрхийн эмэгтэйчүүд			
17	Архи согтууруулах ундааны хамааралтай өрхийн гишүүдэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулах		Өрхийн архины хамааралтай гишүүд	Зорилтод өрхийн архинд орсон гишүүдэд архинаас гарах боломж бий болгосон байна.	ГБХЗХГ, Жаргалтай амьдрал төв,	НТБТ, Сумын ЗДТГ, НТБН
18	Өрхийн цахилгааны болон гал түймэр, бусад эрсдэлт хүчин зүйлийн аюулгүй байдлыг хангах.	Жил бүрийн 5-9 сард	Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн сонгогдсон өрхүүд	Эрсдэлт хүчин зүйлсээс хамгаалагдана.	Онцгой байдлын газар, Эрчим хүч,	Сумын ЗДТГ
19	Ариун цэврийн байгууламжийн нөхцөлийг сайжруулах.			Зориулалтын ариун цэврийн байгууламжтай болсон байна.	ЭМГ БОАЖГ, Аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид	Сумын ЗДТГ
20	"Хогоо ангилан ялгах хөдөлгөөнийг өрнүүлэх (хог хаягдлыг багасгах, ялган ангилах,	Тогтмол	Сонгогдсон өрхүүд	Хог хаягдлыг ялгах мөнгө болгох, орчны цэвэр байдлыг хангах, дахин боловсруулах цэгт тушаах дадал чадварт	БОАЖГ	Сумдын ЗДТГ, Хот тохижилт ОНӨААТҮГ, Цэвэр хот

1	2	3	4	5	6	7
	зориулалтын саванд хадгалах, ачуулах, дахин боловсруулах цэгт тушаах)			суралцана.		ОНӨААТҮГ
21	Тэрбум мод хөдөлгөөнд нэгдэж өрх бүр өөрийн өмчит газраа мод тарих	Жил бүрийн 5,6 сард	Сонгогдсон өрхүүд	Сонгогдсон өрх бүр өөрийн хашаандаа болон амьдарч буй орчиндоо 5-аас доошгүй мод тарьсан байна.	БОАЖГ	Сумын ЗДТГ
22	Оролцоо төсөлд хамруулах	Жил бүрийн тогтоосон хугацаанд	Сонгогдсон өрхийн гишүүд	Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийг мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна.	Политехникийн коллеж, ХХҮГ	Сумын багийн дарга ЗДТГ, засаг
23	Байнгын болон түр ажлын байранд холбон зуучлах	Жил бүр		Өрхийн хөдөлмөрийн насны гишүүдийг ажлын байртай болгоно.	ХХҮГ, Сумын ЗДТГ	Сумын багийн дарга ЗДТГ, засаг
24	Ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх	Жил бүр	Сонгогдсон өрхийн гишүүд	Ажилд орох болон ажлын байрны зөвлөгөөг авах хүсэлтэй иргэдэд өгсөн байна.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Сумын багийн дарга ЗДТГ, ХХҮГ-ын мэргэжилтэн
25	Боломжит төсөл хөтөлбөрүүдийг танилцуулж, дэмжих	Жил бүр		Ажил орлоготой болж амьдралын чанар дээшилнэ.	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Сумын багийн дарга ЗДТГ, засаг

-----000-----